

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГСӨН АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

АУДИТЫН НЭР: ОРОН НУТГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ДҮГНЭЛТ ӨГӨХ
АУДИТЫН КОД: БНА-2024/03-03-НА-НА

Баянхонгор хот 2024 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат

Утас: 70442584 цахим хуудас: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер М.Алтантуяа

Утас: 80112188 цахим хуудас: altantuyam@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Азбаяр

Утас: 99061429 цахим хуудас: azbayarb@audit.gov.mn

Ахлах аудитор Н.Батчимэг

Утас: 91113253 цахим хуудас: batchimegn@audit.gov.mn

Аудитор Д.Даваадорж

Утас: 88953144 цахим хуудас: davaadorjd@audit.gov.mn

Аудитор А.Адилзаяа

Утас: 80870886 цахим хуудас: adilzayaa@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

Агуулга

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	3
ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	5
ТӨСВИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХАД БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ	9
ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШААРДЛАГА.....	10
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ.....	11
НЭГ. ТӨСВИЙН ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ САНАЛ.....	11
ХОЁР. ТӨСВИЙН ЗАРЛАГЫГ БУУРУУЛЖ, ТӨСВИЙН ХӨРӨНГИЙН ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ 12,383.1 САЯ ТӨГРӨГИЙН САНАЛ.....	14
ДҮГНЭЛТ.....	19
ЗӨВЛӨМЖ.....	20
ХАВСРАЛТ.....	21



Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТЭЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын их хурал
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Хүснэгтийн жагсаалт

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Аймгийн аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл	5
Хүснэгт 2	Хүний нөөц	6
Хүснэгт 3	Иргэдийн орлого	7
Хүснэгт 4	Хөдөө аж ахуйн нөөц	7
Хүснэгт 5	Төсвийн 2020-2023 оны гүйцэтгэл	7
Хүснэгт 6	Төсвийн тухай хуулийн шаардлага	10
Хүснэгт 7	Иргэдийн санал аваагүй тусгасан төсөл, арга хэмжээний судалгаа	15
Хүснэгт 8	Авто замын сангийн хөрөнгөөр 2025 онд шинээр хэрэгжүүлэхээр гаргасан жагсаалтад ТЭЗҮ болон урьдчилан тооцоолол байхгүй ТАХ	16
Хүснэгт 9	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын хөрөнгөөр 2025 онд шинээр хэрэгжүүлэхээр гаргасан жагсаалтад ТЭЗҮ болон урьдчилан тооцоолол байхгүй ТАХ	17

Графикийн жагсаалт

№	Тайлбар	Хуудасны дугаар
График 1	Аймгийн Дотоодын нийт бүтээгдэхүүн	6
График 2	Аймгийн ДНБ-ний өсөлт (хувь), нэг хүнд ногдох ДНБ хэмжээ (сая.төг), Инфляцын түвшин	6



Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь “Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын жилийн төсвийн төсөл”, түүнчлэн аймгийн Засаг даргаас тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн жилийн төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргаж, Улсын Их Хурал болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэх” гэсэн заалт, Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/162 дугаар тушаал, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/01 дугаар тушаалыг үндэслэн аудит хийв.

Аудитын зорилт

Баянхонгор аймгийн Засаг даргын 2025 оны төсвийн төсөлд дүн шинжилгээ хийж, төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх, зарлагыг бууруулах, санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргаж аймгийн ИТХ-д өргөн мэдүүлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтуудын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- ✓ Орон нутгийн төсөвт орох татварын болон татварын бус орлогыг бүрэн төлөвлөсөн эсэх
- ✓ Төсвийн зарлагыг арвилан хэмнэлттэй, үр нөлөөтэйгөөр төлөвлөсөн эсэх
- ✓ Төсвийн санхүүжилтийн үр ашигтай байхаар төлөвлөсөн эсэх

Аудитыг хамарсан хүрээ

Баянхонгор аймгийн Засаг даргаас Сангийн яаманд өргөн мэдүүлсэн 2025 оны төсвийн төсөл, аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Нийгмийн бодлогын хэлтэс, Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, аймгийн Татварын газар, ГХБХБГ, ОНӨГ зэрэг бусад шалгагдагч болон хамрагдагч этгээдээс ирүүлсэн холбогдох бусад баримт материалыг хамруулан гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй

Төсвийн төсөлд дүгнэлт гаргах аудитад АДБОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимд тулгуурласан Төрийн аудитын MNS6817:2020 Монгол Улсын стандарт, МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, МУЕА-ын 2022.08.17-ны өдрийн А/67 дугаар тушаалаар баталсан “Төсвийн төсөлд дүгнэлт гаргах аргачлал” зэрэг аудитыг чиглүүлж гарсан бусад заавар, аргачлалыг мөрдөн, аудитад шалгагдагч болон хамрагдагч байгууллагын газар нэгжүүдийн холбогдох албан тушаалтнуудаас нэмэлт тодруулга, лавлагаа, судалгааг авч, ярилцлага хийх, аудитын явцад цуглуулсан баримт материалд дүн шинжилгээ хийх горимыг хэрэгжүүлж нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт өгч байна.



**Аудитад
ашигласан
шалгуур
үзүүлэлтүүд:**

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- ✓ Төрийн аудитын тухай хууль
- ✓ Төсвийн тухай хууль;
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль
- ✓ Сангийн яамны 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”
- ✓ Орон нутгийн 2025 оны төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл, удирдамж

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат хянан удирдаж, аудитын менежер М.Алтантуяа аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Азбаяр, Н.Батчимэг, аудитор Д.Даваадорж, А.Адилзаяа нар хамтран гүйцэтгэв.

Аудитын төлөвлөгөөг 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр батлуулж, талбарын ажлыг гүйцэтгэж, орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн үр ашгийг сайжруулах, зардал бууруулах дүгнэлтийг 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр аймгийн ИТХ-д хүргүүлэв.



ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1-т зааснаар Баянхонгор аймгийн Засаг даргаас ирүүлсэн ТЕЗ-ийн 2025 оны орон нутгийн төсвийн төсөлд Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т заасны дагуу дүгнэлт гаргав.

Баянхонгор аймгийн Засаг даргаас Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.3¹-т заасан цаглавар хугацаанд 2025 оны орон нутгийн төсвийн төслийн нийт зарлагыг 78,175.2 сая төгрөгөөр, санхүүжих эх үүсвэрийг улсын төсвөөс 78.127.7 сая төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлого 47.5 сая төгрөгийг төвлөрүүлэхээр төлөвлөж Сангийн яаманд хүргүүлсэн байна.

УИХ-ын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 64 дугаар “Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” тогтоолын 01 дүгээр хавсралтын 2.1-д хангайн бүсэд Архангай, Баянхонгор, Өвөрхангай аймаг, 3.1-д бүсийн хөгжлийн зорилго нь дэлхий дахинд монголын түүх, төрт ёс, соёлын өвийг түгээн дэлгэрүүлж, дэлхийн нүүдэлчдийн соёлын голомт нутаг, соёлын бүтээлч үйлдвэрлэлд тулгуурлан “Уламжлалт мал аж ахуйн төрөлжсөн бүс бөгөөд хот байгуулалтын дэд бүс болно. хэмээн тодорхойлсон.

Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлэхээр тогтоолд тусгасан байна. Үүнд:

3.1.4.Бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан аймгуудын мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг төрөлжүүлж, Баянхонгор аймагт дадлага, үйлдвэрлэлийн бааз байгуулна.

3.1.28.Баянхонгор аймагт Байдрагийн 30 МВт-ын хүчин чадалтай усан цахилгаан станц барина.

3.1.29.Цэцэрлэг хот- Баянхонгор хот чиглэлийн авто замыг барина.

АЙМГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН 2020-2023 ОНЫ ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ:²

Хүснэгт 1. Аймгийн аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл (сая.төг)

Нийт үйлдвэрлэл	2020 он	2021 он	2022 он	2023 он
Уул уурхай, олборлолт	35,222.6	46,646.2	66,844.4	50,998.2
Боловсруулах үйлдвэрлэл	1,462.7	2,455.0	2,144.4	2,470.3
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	6,445.4	7,072.0	6,695.3	10,847.4
Ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	1,869.2	2,162.5	2,663.1	2,556.4
Дүн	44,999.9	58,335.7	78,347.2	66,872.3

¹ төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн саналаа жил бүрийн 07 дугаар сарын 25-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн аудитын байгууллага, Улсын Их Хуралд хүргүүлж, нийтэд ил тод мэдээлэх

² Эх сурвалж- <https://data.nso.mn/?aimagid=64>



График 1. Аймгийн Дотоодын нийт бүтээгдэхүүн (тэрбум төг)




График 2. Аймгийн ДНБ-ний өсөлт (хувь), нэг хүнд ногдох ДНБ хэмжээ (сая.төг),
Инфляцын түвшин (хувь)



Хүснэгт 2. Хөдөлмөр эрхлэлт

Үзүүлэлт	2020 он	2021 он	2022 он	2023 он
Хүн амын тоо	89329	89975	89643	88499
Эдийн засгийн идэвхтэй хүн ам /мянган хүн/	43.8	34.3	44.1	44.7
Ажиллагчдын тоо /мянган хүн/	41.2	29.1	29.1	41.5
Ажилгүйдлийн түвшин /хувь/	6.9	15.5	13	8.2
Малчдын тоо /мянган хүн/	23.2	23.1	22.6	21.9



Хүснэгт 3. Иргэдийн дундаж орлого

Үзүүлэлт	2020 он	2021 он	2022 он	2023 он
ААНБ-ын ажиллагчдын сарын дундаж цалин мянган төгрөг	863.3	912.0	1024.5	1353.2
Нэг өрхийн сарын дундаж орлого /бүсээр/ мянган төгрөг	1,235.8	1,479.5	1,636.7	1,947.0
Нэг өрхийн сарын дундаж зарлага /бүсээр/ мянган төгрөг	1,293.8	1,395.9	1,669.8	2,082.4

Хүснэгт 4. Хөдөө аж ахуйн салбарын зарим үзүүлэлт

Үзүүлэлт	2020 он	2021 он	2022 он	2023 он
Малын тоо (сая толгой)	3.8	3.1	3.7	4.7
Тариалсан талбай (га)	560.9	691.1	500.8	506.8
Баянхонгор аймгийн ХААН салбарт орсон УТХО (сая.төг)		9,356.1	5,706.1	3,843.8
Тухайлбал: Шинэ хөдөө төслийн хүрээнд бэлтгэсэн хөрөнгө				
Хөрөнгийн нэр			Хэмжих нэгж	Тоо хэмжээ
Хүнсний ногооны хүлэмжийн иж бүрдэл			ширхэг	15
25-30 морины хүчтэй дугуйт трактор			Ширхэг	6
Трактор 80-90 морины хүчтэй			Ширхэг	6
Дагалдах тоног төхөөрөмж (Анжис, Үрлүүр, Дискен хадуур, Тармуур, Өвс хамагч, Мотоблок)			Ширхэг	6
Сарлагийн өсвөр бух			Толгой	6
Сэлэнгэ үүлдрийн өсвөр бух			Толгой	20
Сэлэнгэ үүлдрийн өсвөр гунжин үнээ			Толгой	43
Баянбулаг омгийн хурган хуц			Толгой	450
Баянбулаг омгийн төлгөн хуц			Толгой	50
Баянбулаг омгийн өсвөр хээлтэгч			Толгой	400
Малын зохиомол хээлтүүлгийн зөөврийн багаж, ачааны автомашин			Иж бүрэн	2
Сүлжмэлийн тоног төхөөрөмж			Багц	1
Иж бүрдэл хүлэмж 4*8=32 м2			Ширхэг	42
Иж бүрдэл хүлэмж 6*10=60м2			Ширхэг	23
Төмс хураагч			Ширхэг	2
Тусгай үйлчилгээний автомашин			Ширхэг	15

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ:

Хүснэгт 5. Төсвийн 2020-2023 оны гүйцэтгэл

/сая төгрөг/

Үзүүлэлт		2020	2021	2022	2023
Орон нутгийн орлого	Төлөвлөгөө	13,272.8	13,826.6	16,617.2	20,190.1
	Гүйцэтгэл	14,953.1	17,281.0	21,685.3	23,644.6
	Биелэлт	112.7%	125.0%	130.5%	117.1%
Баталсан төсөв	Төлөвлөгөө	94,238.1	47,547.9	58,993.2	77,916.3
	Гүйцэтгэл	87,308.5	41,797.0	51,608.7	69,931.0
	Биелэлт	92.6%	87.9%	87.5%	89.8%
Санхүүгийн дэмжлэг	Гүйцэтгэл	18,764.2	17,503.5	17,677.9	23,195.8
Аудитын зөвлөмжийн хэрэгжилт					
Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудит		70.5%	83.3%	80.6%	71.3%



ОРОН НУТГИЙН 2025 ОНЫ
ТӨСВИЙН ТӨСӨЛД ДҮГНЭЛТ ӨГӨХ

Жижиг дунд үйлдвэр хөгжүүлж ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор төсвөөс гарсан зээлийн сан – 7,561.4 сая.төг					
Хоршоо хөгжүүлэх сан	Сан	5,114.6	5,174.1	5,240.6	5,297.9
	Зээлийн авлага	3,636.8	2,581.3	4,094.5	3,913.6
	Мөнгөн үлдэгдэл	1,477.8	2,592.8	1,146.1	1,384.3
	Төлөвлөгөө	1,499.0	2,385.0	3,970.3	2,409.4
	Гүйцэтгэл	954.6	673.8	2,356.2	921.1
	Биелэлт	63.7%	28.3%	59.3%	38.2%
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	Сан	1,144.4	1,407.4	2,100.2	2,263.5
	Зээлийн авлага	1,837.8	1,563.8	2,057.6	2,617.8



ТӨСВИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХАД БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ

Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсвийн төслийг боловсруулахдаа Сангийн яамнаас ирүүлсэн “Орон нутгийн 2025 оны төсвийн төсөл боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл”-ийг удирдлага болгосон байна. Үүнд:

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган талаар;

1. Орон нутгийн 2025 оны төсвийн орлогын чиглэлээр

✓ Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4.1-т аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 60 хувь нь улсын төсвийн орлого байхаар, мөн хуулийн 23 дугаар зүйлийн 23.6.10-т аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувь нь орон нутгийн төсвийн орлого байхаар тус тус заасан. Иймд Улсын Их Хурлаар баталсан аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогын дүнг нэмэгдүүлэхгүй байх.

✓ Байгалын нөөц ашиглах зөвшөөрөл олгохдоо зөвшөөрөл эзэмшигчийн талаар мэдээлэл бүртгэлийн санг үүсгэн баяжуулж, харьяалах татварын албанд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн талаарх мэдээллийг тухай бүр хүргүүлэн ажиллах;

✓ Усны нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх чиглэлээр сум, дүүргийн Засаг дарга, Усны газар, сав газрын захиргаа, төвлөрсөн ус хангамжийн байгууллага, татварын алба ус ашиглагчийн үйлдвэр, үйлчилгээнд ашигласан усны хэмжээг бодитоор тодорхойлон, төлбөрийн орлогыг орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлэхэд хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлэх.

✓ Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоох татварын хувь, хэмжээг бүсийн тэргүүлэх чиглэл, нийгэм, эдийн засгийн онцлогт нийцүүлэн тогтоож, 2025 оны төсвийн жилээс мөрдөх арга хэмжээ авах.

2. Орон нутгийн 2025 оны төсвийн зарлагын чиглэлээр

✓ Засгийн газраас эрчим хүчний салбарын шинэчлэлийг хэрэгжүүлж байгаатай холбоотойгоор орон нутгийн өмчийн байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг Эрчим хүчний яам болон Эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс ирүүлсэн тооцооллын дагуу орон нутгийн суурь зардалд тусгасан. Төсвийн төслийг боловсруулахдаа гэрэл, цахилгаан, түлш, халаалтын зардлыг холбогдох байгууллагаас тогтоосон үнэ тариф, тогтоолын дагуу тооцож тусгах;

✓ Засгийн газрын 2023 оны 312 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд Худалдан авах ажиллагааны газрыг ажиллуулахаар шийдвэрлэсэн. Тогтоолын хэрэгжилтийг хангаж 2025 оны орон нутгийн суурь зарлагад тус байгууллагыг үүсгэн, Орон нутгийн өмчийн газартай дүйцүүлэн 7 орон тоотой үйл ажиллагаа явуулахаар тооцон зардлыг тусгасан тул 2025 оны төсвийн төслөө боловсруулж батлуулахдаа Сангийн яамнаас хянасан орон тооноос хэтрүүлэхгүй байхад анхаарах.

✓ Авто замын тухай хуулийн 25.2.1-25.2.7-д заасан орлогын нийлбэр дүнгээр тооцож аймаг, нийслэлийн авто замын сангийн зардлыг орон нутгийн суурь зардалд тусгасан бөгөөд сангийн хөрөнгийг “Журам батлах тухай” Засгийн газрын 2019 оны 312 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Авто замын санд хөрөнгө, төвлөрүүлэх, захиран зарцуулах журам”-ын дагуу хэрэгжилтийг хангах ажиллахыг анхаарах зэрэг чиглэлийг үндэслэн төсвийн төслийг боловсруулсан байна.



ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШААРДЛАГА

Баянхонгор аймгийн Засаг даргын 2025 оны төсвийн төслийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 1а/851 дүгээр албан бичгээр ирүүлсэн боловч Төсвийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.5-т заасан төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг гаргаж ирүүлээгүй байна.

Хүснэгт 6. Төсвийн тухай хуулийн шаардлага

№	Төсвийн тухай хуулийн заалт	Тусгасан эсэх	Тайлбар
1	33.2.1.төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяалагдах шатны төсөвтөө тухайн жилд төвлөрүүлэх орлого, харьяалах төсвийн байгууллагын өөрийн орлого	Тийм	
2	33.2.2.төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн төсвийн зарлагын дээд хэмжээ, урсгал болон хөрөнгийн зарлагын дээд хэмжээ	Тийм	
3	33.2.4.бусад шатны төсөвт олгох орлогын шилжүүлэг, санхүүгийн дэмжлэг	Тийм	
4	33.2.5.төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг хавсралтаар	Ирүүлээгүй	Жил бүр төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитаар зөвлөмж хүргүүлсэн боловч хэрэгжүүлэхгүй байна.
5	33.2.6.хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар /нэр, байршил, хүчин чадал, хэрэгжүүлэх хугацаа, төсөвт өртөг, санхүүжүүлэх эх үүсвэр, тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүн/	Тийм	

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.6-д “Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг жил бүрийн 10 дугаар сарын 01-ний дотор батална” гэж заасан ба аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөг ирүүлээгүй болно.

Жич: УИХ-ын 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар баталсан “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай” хуульд Монгол Улсын Ерөнхийлөгч тус хуульд бүхэлд нь хориг тавьсантай холбоотойгоор аймгийн суурь орлого, зарлагын дүн батлагдаагүйгээс аймгийн 2025 төсвийг боловсруулах боломжгүй байгаа тухайгаа аймгийн Засаг дарга 2024.11.25-ны өдрийн 1а/873 дугаар албан бичгээр аймгийн ИТХ-ын даргад хүргүүлсэн байна.



БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ

Баянхонгор аймгийн Засаг даргын 2025 оны төсвийн төсөлд санхүүгийн дэмжлэг 41,955.9 сая, орон нутгийн орлого 40,287.5 сая, байгууллагын өөрийн орлого 75.0 сая, ОНХНС-аас 23,502.4 сая, орон нутгийн төсвөөс 2,604.3 сая, хандивын орлого 1,200.0 сая нийт эх үүсвэр 109,625.1 сая, нийт зардлыг 109,625.1 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр ирүүлсэн байна.

Аймгийн ТЭЗ-ийн 2025 оны төсвийн төсөлд аудит хийж дараах саналыг аймгийн ИТХ, Засаг даргад хүргүүлж байна.

НЭГ. ТӨСВИЙН ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ САНАЛ

Орон нутгийн суурь орлого 40,287.5 сая төгрөгийг 2,897.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэх саналыг хүргүүлж байна.

Санал 1. Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын татварыг 19,200.0 сая төгрөгөөр төлөвлөснийг 1,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 20,200.0 сая төгрөг болгох.

Үндэслэл: Төсвийн төсөлд тусгагдсан төсөвт байгууллагуудын цалингийн зардлын өсөлт 30 хувиар нэмэгдүүлэн тооцсон, тус орлогын 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэл 17,706.3 сая төгрөг байхад 2025 оны төсвийн төсөлд 19,200.0 сая төгрөгөөр буюу 8 хувийн өсөлтөөр тооцсон байна.

Шинэжинст сумын нутагт уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг “Эрдэнэ Монгол” ХХК-ийн ТЭЗҮ-д хувь хүний орлогын албан татварт 5 жилийн хугацаанд 1,940.0 сая төгрөгөөр тооцсон бөгөөд тус төслийн хүрээнд дагалдах үйлдвэрлэл, үйлчилгээний бүтээн байгуулалт хийгдэж байгаатай холбоотойгоор шинээр ажлын байр нэмэгдэхээр байна.

Иймд дээрх өсөлтийн хувиудыг харгалзан цалин хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн татварын орлогын хүлээгдэж буй гүйцэтгэлийг 15 хувиар өсгөж тооцоход 1,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.

Санал 2. Газрын төлбөрийн 859.0 сая төгрөгийн татварын орлогыг 26.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж 885.4 сая төгрөгөөр төлөвлөх

Үндэслэл: Төрийн аудитын байгууллагаас 2024 онд “Уул уурхайн аж ахуйн нэгжүүдээс төсөвт төвлөрүүлсэн орлого, орон нутагт хийсэн хөрөнгө оруулалт түүний үр ашиг”-т хийсэн гүйцэтгэлийн аудитаар газрын удирдлагын мэдээллийн системд уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг 7 аж ахуйн нэгжийн 1,102 га талбайг дутуу оруулснаас газрын төлбөрийн ногдол хийгээгүй тул мэдээллийг оруулж газрын төлбөрийн ногдол хийх албан шаардлагыг аймгийн ГХБХБГ-т хүргүүлсэн.

Аймгийн мэдээллийн системд ороогүй 1,102 га талбайн газрын төлбөрийн ногдлыг тооцуулахад 26.4 сая төгрөг байна. Иймд газрын төлбөрийн орлогыг 26.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.



Санал 3. Газрын дуудлага худалдааны орлогыг 50.0 сая төгрөгөөр төлөвлөснийг 200.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 250.0 сая төгрөгөөр төлөвлөх

Үндэслэл: Газрын дуудлага худалдааны орлогыг 2022 онд 200.0 сая төгрөг төлөвлөснөөс 315.2 сая төгрөг, 2023 оны 390.0 сая төгрөг төлөвлөснөөс 279.9 сая төгрөгийн орлого төвлөрсөн байна.

Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд 2025 онд 12 сумын 32 нэгж талбарт дуудлага худалдаа зохион байгуулахаар төсөл ирүүлсэн ба 50.0 сая төгрөгөөр төлөвлөсөн нь 2 жилийн гүйцэтгэлтэй уялдахгүй байна.

Иймд газрын дуудлага худалдааны орлогыг сүүлийн 2 жилийн гүйцэтгэлийн дундажтай уялдуулж 200.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 250.0 сая төгрөгөөр төлөвлөх.

Санал 4. Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлогыг 70.0 сая төгрөгөөр төлөвлөснийг 418.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 488.0 сая төгрөг болгох

Үндэслэл: Аймгийн ИТХ-ын хуралдааны 2022 оны 10/41 дүгээр тогтоолоор Чандмань-Баянхонгор ХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй “Хонгор-1000 дулаан үйлдвэрлэлийн барилга байгууламж”-ийг 10 жилийн хугацаатайгаар уралдаант шалгаруулалтаар хувьчилсан ба эргэн төлөлтийн хуваариар 2025 онд 203.2 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлнэ.

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2023 оны 13/13 дугаар тогтоолоор аймгийн Баянхонгор тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй зам талбайн хавтан үйлдвэрлэлийн иж бүрэн тоног төхөөрөмжийг 3 жилийн хугацаатайгаар уралдаант шалгаруулалтаар хувьчилсан ба эргэн төлөлтийн хуваариар 2025 онд 173.4 сая төгрөг төсөвт төвлөрүүлнэ.

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2022 оны 9/18 дугаар тогтоолоор Байгаль орчин аялал, жуулчлалын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Виртуал студийн барилга, тоног төхөөрөмжийг 8 жилийн хугацаатайгаар уралдаант шалгаруулалтаар хувьчилсан ба 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдөр гэрээг шинэчлэн байгуулж 2025 онд 28.1 сая төгрөг төсөвт төвлөрүүлнэ.

Мөн аймгийн ОНӨГ-ын 2025 онд төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөнд нээлттэй дуудлага худалдаагаар 11 тээврийн хэрэгсэл худалдаж 33.5 сая, уралдаант шалгаруулалтын аргаар 1 үл хөдлөх хөрөнгө хувьчилж 39.8 сая төгрөг оруулахаар төлөвлөсөн байна. Дээрх хувьчлах үнэнд Аймгийн ИТХ-ын даргын 2024 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн “Эд хөрөнгө хувьчлах тухай” 60 дугаар захирамжаар “Оточ номгон” ӨЭМТ-ийн барилгыг хувьчлах шийдвэр гаргахдаа газрын үнэ 10.0 сая төгрөгийг оруулахгүйгээр тооцсон тул газрын үнийг нэмж тооцох.

Уралдаант сонгон шалгаруулалт болон гэрээний эргэн төлөлтөөс орон нутгийн орлогод нийт 488.0 сая төгрөг төвлөрүүлэх боломжтой тул Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлогыг 418.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх саналтай байна.



Санал 5. Ан амьтны нөөц ашигласны орлогыг 550.0 сая төгрөгөөр төлөвлөснийг 1,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 1,550.0 сая төгрөг болгох.

Үндэслэл: Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогыг орон нутгийн төсвийн орлогод бага хэмжээгээр төлөвлөж, давуулан биелүүлсэн орлогыг сумдын ИТХ-аар тодотгон зарцуулж байгаа нь төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулах нөхцөл бүрдэж байна.

Орон нутгийн төсвийн орлогод ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого 2022 онд 4,456.5 сая, 2023 онд 3,544.1 сая төгрөг төвлөрсөн байна.

Сүүлийн 2 жилийн дундаж орлого 4,050.3 сая төгрөг байгаа бөгөөд 2024 онд 2,010.1 сая төгрөгийн орлого оруулахаар төлөвлөснөөс 2024 оны 10 дугаар сарын байдлаар 2,795.2 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Иймд өмнөх онуудын гүйцэтгэлтэй уялдуулан 2025 оны төсвийн төсөлд Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогыг 1,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөснөөр гэнэтийн орлогыг үр ашиггүй зүйлд тодотгон зарцуулдаг байдлыг таслан зогсоож, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу үр ашигтай зарцуулах боломж бүрдэнэ.

Санал 6. Ус, рашаан ашигласны төлбөрийн орлогыг 550.0 сая төгрөгөөр төлөвлөснийг 703.3 сая төгрөг болгон 153.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэх.

Үндэслэл: Шинэжинст суманд үйл ажиллагаа явуулах “Эрдэнэ Монгол” ХХК-ийн Баянхөндий төсөл 2025 онд олборлолтын үйл ажиллагаа явуулж эхлэхээр бэлтгэл ажлаа хангаж байна.

Уул уурхайн Баянхөндий төсөл нь төслийн хугацаанд 1,840.0 сая төгрөгийн усны төлбөрийг орон нутгийн төсөвт оруулах ТЭЗҮ-ийн тооцоо гарсан байна.

Иймд 2025 оны ус, рашааны ашигласны төлбөрийг 153.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөх.

Санал 7. Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогыг 80.0 сая төгрөгөөр төлөвлөснийг 100.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 180.0 сая төгрөгөөр төлөвлөх.

Үндэслэл: Төсвийн төсөлд Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогыг Сангийн яам 80.0 сая төгрөгөөр хянаж ирүүлсэн ба аудитын явцад Шинэжинст сумын Баянхөндийн уурхайд ашигт малтмалын үйл ажиллагаа явуулж буй “Эрдэнэ Монгол” ХХК-аас 2024 онд тус төрлийн төлбөрийн орлогоор 438.9 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого 2023 онд 200.5 сая төгрөг, 2024 оны 10 дугаар сарын гүйцэтгэлээр 467.8 сая төгрөг орж сүүлийн 2 жилд 195-225 хувиар орлогын төлөвлөгөө давж биелсэн байна.

Баацагаан суманд хийгдэж буй бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээ болон Баянхонгор сумын Шинэ суурьшлын бүсийн бүтээн байгуулалт, 2025 онд хэрэгжүүлэх Шаргалжуут чиглэлийн 54.2 км зам, Замын сангийн хөрөнгөөр



Баянхонгор суманд 1км авто зам барих зэрэг бусад улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалттай холбогдуулан түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого нэмэгдэхээр байна.

Иймд Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогыг 100.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 180.0 сая төгрөгийн орлого оруулах боломжтой байна.

Үндэслэл: Төсвийн төсөлд Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогыг Сангийн яам 80.0 сая төгрөгөөр хянаж ирүүлсэн ба аудитын явцад Шинэжинст сумын Баянхөндийн уурхайд ашигт малтмалын үйл ажиллагаа явуулж буй “Эрдэнэ Монгол” ХХК-аас 2024 онд тус төрлийн төлбөрийн орлогоор 438.9 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого 2023 онд 200.5 сая төгрөг, 2024 оны 10 дугаар сарын гүйцэтгэлээр 467.8 сая төгрөг орж сүүлийн 2 жилд 195-225 хувиар орлогын төлөвлөгөө давж биелсэн байна.

Баацагаан суманд хийгдэж буй бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээ болон Баянхонгор сумын Шинэ суурьшлын бүсийн бүтээн байгуулалт, 2025 онд хэрэгжүүлэх Шаргалжуут чиглэлийн 54.2 км зам, Замын сангийн хөрөнгөөр Баянхонгор суманд 1км авто зам барих зэрэг бусад улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалттай холбогдуулан түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого нэмэгдэхээр байна.

Иймд Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогыг 100.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 180.0 сая төгрөгийн орлого оруулах боломжтой байна.

ХОЁР. ТӨСВИЙН ЗАРЛАГЫГ БУУРУУЛЖ, ТӨСВИЙН ХӨРӨНГИЙН ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ 12,383.1 САЯ ТӨГРӨГИЙН САНАЛ

Санал 1: Аймгийн ТЕЗ-ийн нийт дүнгээр бичиг хэргийн зардлыг 150.0 сая төгрөгөөр бууруулах.

Үндэслэл: Засгийн газрын 2024 оны 163 дугаар тогтоолоор Төрийн байгууллагын үйл ажиллагааг цахимжуулах хүрээнд харьяа салбар байгууллагын бичиг хэрэг, шуудангийн зардлыг 50-аас доошгүй хувиар бууруулах талаар зөвлөсөн.

Аймгийн ТЕЗ-ийн нийт дүнгээр Бичиг хэргийн зардлыг 308.0 сая төгрөгөөр төлөвлөсөн бөгөөд 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 167.0 сая төгрөг зарцуулахаар тооцоо гарч байгаа тул 150.0 сая төгрөгөөр бууруулах саналтай байна.



Санал 2. Аймгийн ОНХС-ийн 2025 оны хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөлд иргэдийн санал аваагүй 1,900.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 900.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 2 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байгаа тул иргэдийн санал авсан төсөл, арга хэмжээг тусгаж төсвийн үр ашгийг дээшлүүлэх

Үндэслэл: Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн жагсаалтыг Баянхонгор сум болон бусад сумдаас ирүүлсэн иргэдийн санал авч эрэмбэлсэн жагсаалтыг авч үзэхэд төсвийн төсөлд иргэдийн санал аваагүй, ТЭЗҮ хийгээгүй 900.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй доорх 2 төсөл арга хэмжээг тусгасан байна.

Хүснэгт 7. Иргэдийн санал аваагүй тусгасан төсөл, арга хэмжээний судалгаа /сая.төг/

№	ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ	ЭХЛЭХ ОН	ДУУСАХ ОН	ТӨСӨВТ ӨРТӨГ	ТУХАЙН ОНД БАТЛАГДСАН	Иргэдийн санал
2.5	Бүжгийн ордон байгуулах	2025	2025	700.0	350.0	Иргэдийн санал аваагүй, ТЭЗҮ байхгүй
2.6	Нэгдсэн эмнэлгийн ажилчдын спорт заал барих	2024	2024	1,200.0	550.0	Иргэдийн санал аваагүй, ТЭЗҮ байхгүй
				1,900.0	900.0	

Эх сурвалж: Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төсөл

Иймд аймгийн ОНХС-ийн 2025 оны хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөлд иргэдийн санал авч төсөвлөлтийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээг тусгаж төсвийн үр ашгийг дээшлүүлэхийг санал болгож байна.

Санал 3. Орон нутгийн төсвөөс 2025 онд хийгдэх төрийн болон орон нутгийн өмчийн барилга байгууламжийн их засварын жагсаалтад шинээр хэрэгжүүлэхээр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын албаны конторын засварын ажлыг 205.7 сая төгрөгөөр тусгасан нь төсвийн үр ашгийг сайжруулах шаардлагатай.

Үндэслэл: Засварын ажлын төсөвт дүн шинжилгээ хийхэд сандал, ширээ бэлтгэх зардлыг тусгасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5³, амралтын өрөөний засвар хийхээр төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1⁴ -д заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчимтай нийцэхгүй байна.

Иймд аймгийн барилга, байгууламжийн их засварын жагсаалтад 2025 онд шинээр хэрэгжүүлэхээр тусгасан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны конторын засварын ажлын 205.7 сая төгрөгийн хөрөнгийн төлөвлөлтийг Төсвийн тухай хуульд нийцүүлэн үр ашигтай төлөвлөж, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэхийг санал болгож байна.

Санал 4. Авто замын сангийн хөрөнгөөр 2025 онд шинээр хэрэгжүүлэхээр тусгасан жагсаалтад 333.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 4 төсөл арга хэмжээг бүрэн санхүүжүүлэхээр тусгасан боловч тооцоолол судалгаа, зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл байхгүй тул төсөвлөлтийн шаардлага хангасан үр ашигтай төсөл арга хэмжээнд төлөвлөх.

³ батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;

⁴ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;



Үндэслэл: Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ээс ирүүлсэн авто замын сангийн 2025 онд хийгдэх жагсаалтад 333.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 4 төсөл, арга хэмжээг бүрэн санхүүжүүлэхээр тусгасан нь зураг төсөл болон урьдчилан тооцоолол байхгүй төсөвлөлтийн шаардлага хангаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4⁵ дэх заалтыг зөрчиж байна.

Хүснэгт 8. Авто замын сангийн хөрөнгөөр 2025 онд шинээр хэрэгжүүлэхээр гаргасан жагсаалтад ТЭЗҮ болон урьдчилан тооцоолол байхгүй ТАХ /сая.төг/

№	ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ	ЭХЛЭХ ОН	ДУУСАХ ОН	ТӨСӨВТ ӨРТӨГ	ТУХАЙН ОНД БАТЛАГДСАН	Зураг төсөв
ШИНЭЭР ЭХЛЭХ ТӨСӨЛ ӨРГӨ ХЭМЖЭЭ						
2.2	Баянхонгор сумын 1-р багийн нийтийн эзэмшлийн зам талбайн засвар	2025	2025	20.0	20.0	ТЭЗҮ байхгүй
2.13	Баянхонгор сумын доторх эвдэрсэн талбайд замын нөхөөс хийх	2025	2025	100.0	100.0	ТЭЗҮ байхгүй
2.14	Баянхонгор сумын гэрлэн дохионы шинэчлэл, засвар үйлчилгээ	2025	2025	95.0	95.0	ТЭЗҮ байхгүй
2.15	Баянхонгор сумын А зэрэглэлийн бүсийн тоосжилтыг бууруулах зорилгоор шаардлагатай газруудад хучилт хийх	2025	2025	118.8	118.8	ТЭЗҮ байхгүй
				333.8	333.8	

Эх сурвалж: Авто замын сангийн хөрөнгөөр 2025 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтаас

Иймд Авто замын сангийн хөрөнгөөр 2025 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтаас дээрх 333.8 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээг Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4⁶ дэх заалтад нийцүүлэн үр ашигтай төлөвлөж, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэхийг санал болгож байна.

Санал 5. Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын хөрөнгөөр 2025 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад туссан төсөвлөлтийн шаардлага хангаагүй, ТЭЗҮ болон урьдчилан тооцоолол хийгээгүй 165.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 3 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөснийг хуульд нийцүүлэн үр ашгийг сайжруулах.

Үндэслэл: Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын хөрөнгөөр 2025 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад туссан төсөвлөлтийн шаардлага хангаагүй, ТЭЗҮ болон урьдчилан тооцоолол хийгээгүй 165.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий дараах 3 төсөл, арга хэмжээ туссан байна. Үүнд:

⁵ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

⁶ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.



Хүснэгт 9. Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын хөрөнгөөр 2025 онд шинээр хэрэгжүүлэхээр гаргасан жагсаалтад ТЭЗҮ болон урьдчилан тооцоолол байхгүй ТАХ

№	ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ	ЭХЛЭХ ОН	ДУУСАХ ОН	ТӨСӨВТ ӨРТӨГ	ТУХАЙН ОНД БАТЛАГДСАН	Зураг төсөв
ШИНЭЭР ЭХЛЭХ ТӨСӨЛ ӨРГӨ ХЭМЖЭЭ						
1	Баянхонгор сумын Дуурсах 3-р багийн шинэ ойн зурваст хурын ус хуримтлуулах хөв байгуулах	2025	2025	100.0	100.0	ТЭЗҮ байхгүй
2	"Бид нэг голын хүүхдүүд" хөтөлбөр хэрэгжүүлэх	2025	2025	25.0	25.0	ТЭЗҮ байхгүй
3	Шаардлагатай сумдын худагт ус цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулах	2025	2025	40.0	40.0	ТЭЗҮ байхгүй
				165.0	165.0	

Баянхонгор сумын 2, 3, 6 дугаар багийн араар хийсэн хиймэл нуурын ашиглалтыг сайжруулж, дахин хөв байгуулах шаардлагатай эсэхийг судлах.

Иймд Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын хөрөнгөөр 2025 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтаас дээрх 165.0 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээг Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4⁷ дэх заалтад нийцүүлэн үр ашигтай төлөвлөж, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэхийг санал болгож байна.

Санал 6. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Баянхонгор аймагт үйлдвэрлэл хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх зорилтын хүрээнд хийгдэж байнгын ашиглалтад хүлээн авсан 10,628.6 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээний үр ашгийг нэмэгдүүлэх.

Үндэслэл: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Баянхонгор аймагт үйлдвэрлэл хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх зорилтын хүрээнд хийгдэж байнгын ашиглалтад хүлээн авсан 3,848.1 сая төгрөгийн өртөг бүхий ингэний сүүний үйлдвэр, 1,911.3 сая төгрөгийн өртөг бүхий өвлийн хүлэмж, 4,869.2 сая төгрөгийн мах ногооны зорь ашиглалтгүй байгаа тул цаашид хөрөнгийг хэрхэн үр ашигтай ашиглах талаар бодлого гаргах шаардлага үүсэж байна.

Нэмэлт мэдээлэл: Төрийн аудитын байгууллагаас 2024 оны эхний хагас жилд хийсэн Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын аудитаар Баянхонгор аймгийн Өлзийт суманд хэрэгжиж байгаа Хөдөө аж ахуй кластер дэд төслийн хүрээнд хийж буй бүтээн байгуулалтын төсвийн зарцуулалтад орон нутгаас тавих хяналт хангалтгүйгээс төсвийн хөрөнгийн үргүй зардал гарч байгаа зөрчил илэрсэн тул орон нутгийн зүгээс бодлогын хэмжээнд анхаарч төсвийн үр ашгийг сайжруулах шаардлагатай байна.

Иймд дээрх хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон үйлдвэрүүдийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр эсвэл уралдаант сонгон шалгаруулалт, дуудлага худалдаа зохион байгуулах замаар хөрөнгийн үр ашгийг дээшлүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэх боломж байна.

⁷ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.



Санал 7. Баянхонгор аймгийн ИТХ-д хандивын орлогыг төлөвлөхгүй байх саналыг уламжилж байна.

Үндэслэл: Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2⁸-т заасан үйлчилгээ үзүүлдэг байгууллагаас бусад байгууллага хандив авахгүй гэж заасан байхад аймгийн Засаг даргын 2025 оны төсвийн төсөлд 1,200.0 сая төгрөгийн хандивын орлогыг төлөвлөсөн байна.

Хандивын орлогын төлөвлөгөө гүйцэтгэлийг сүүлийн 3 жилээр харьцуулахад 2021 онд 577.2 сая төгрөг төлөвлөснөөс 84.0 сая төгрөг, 2022 онд 375.5 сая төгрөг төлөвлөснөөс 257.8 сая төгрөг, 2023 онд 3,980.1 сая төгрөг төлөвлөснөөс 1,800.1 сая төгрөгийн хандив орлого төвлөрч гүйцэтгэл 14.6-68.7 хувь байна

Хандивын орлогыг төлөвлөснөөр төсвийн орлогын төлөвлөгөө тасрах, төсвийн зардлыг хий өсгөж төсвийн гүйцэтгэл хангагдахгүй байх эрсдэл үүсэж байна.

Иймд Төсвийн тухай хуультай 23 дугаар 23.7, 25 дугаар зүйл, 60 дугаар 60.3.5 дахь заалтай нийцүүлэх асуудлыг аймгийн ИТХ-д толилуулж байна.

⁸ Хуульд өөрөөр заагаагүй бол зөвхөн доор дурдсан нийгмийн үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллага энэ хуульд заасан журмын дагуу хандив, тусламж авч болно:



ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс болон аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт гаргаж байна.

1. Төрийн аудитын газраас жил бүрийн аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөлд Төсвийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.5-т заасан төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг гаргах талаар зөвлөмж өгдөг боловч хэрэгжүүлэхгүй байна.
2. Баянхонгор аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсвийн төсөлд тусгагдсан төсвийн суурь орлогыг 2,897.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, суурь зарлагыг 150.0 сая төгрөгөөр бууруулах, төсвийн үр ашгийг 12,233.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, нийт 15,280.8 сая төгрөгийн санал, дүгнэлтийг хүргүүлж байна.
3. Төсвийн төсөлд зарим хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, 60 дугаар зүйлийн 60.3-т заасан шаардлагад нийцэхгүй байна.
4. Аймгийн хөгжлийн хөтөлбөр, төсвийн төслийг төлөвлөхдөө төр хувийн хэвшлийн түншлэл, оролцоо (инноваци), санхүүгийн нөөц боломжийг бүрэн тусгаагүй зөвхөн төсвийн хөрөнгөөр төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр тооцсон байна.
5. Орон нутгийн хөгжлийн зорилтыг хангах зорилгоор улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн ашиглал, хадгалалт, хамгаалалт, төслийн хэрэгжилтэд явцыг хянах мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаанаас шалтгаалан төсвийн үр ашиг төлөвлөсөн хугацаандаа үр өгөөжөө өгөхгүй байх, үргүй зардал болж хувирах эрсдэл өндөр байна.



ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Нэг. Баянхонгор аймгийн ИТХ-д толилуулах нь:

- Хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон үйлдвэрүүдийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр эсвэл уралдаант сонгон шалгаруулалт, дуудлага худалдаа зохион байгуулах замаар хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлж ажлын байр бий болгох боломж байна.
- Хандивын орлогыг төлөвлөснөөр төсвийн гүйцэтгэл тасрах, төсвийн зардлыг хий өсгөх эрсдэлтэй тул хандивын орлогыг төлөвлөхгүй байх шаардлага үүсэж байна.
- Орон нутгийн хөгжлийн зорилтыг хангах зорилгоор улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн ашиглал, хадгалалт, хамгаалалт, төслийн хэрэгжилтэд явцыг хянах мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаанаас шалтгаалан төсвийн үр ашиг төлөвлөсөн хугацаандаа үр өгөөжөө өгөхгүй байх, үргүй зардал болж хувирах эрсдэл өндөр байна.

Хоёр. Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч Д.Мөнхсайхан танаа

- ✓ Төсвийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.5-т заасан хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг гаргахад мэргэжилтнүүдийн мэдлэг ур чадвар дутагдаж байгаа тул мэргэжлийн шинжээчийн туслалцаа авах байдлаар хуулийг хэрэгжилтийг хангах.
- ✓ Төсвийн төсөлд Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, 60 дугаар зүйлийн 60.3-т заасан төсөвлөлтийн шаардлагыг хангасан төсөл, арга хэмжээг тусгах.
- ✓ Аймгийн хөгжлийн хөтөлбөр, төсвийн төслийг төлөвлөхдөө төр хувийн хэвшлийн түншлэл, оролцоо (инноваци), санхүүгийн нөөц боломжийг бүрэн тусгах боломжийг судлах.



ХАВСРАЛТ

Хавсралт 01 - ТӨСВИЙН ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ САНАЛ

Хавсралт 02 - ТӨСВИЙН ЗАРЛАГЫГ БУУРУУЛАХ САНАЛ

Хавсралт 03 - ТӨСВИЙН ХӨРӨНГИЙН ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ САНАЛ

ТӨСВИЙН ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ САНАЛ

(сая төгрөг)

№	Татварын болон татварын бус орлого	Мөнгөн дүн
1	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын татварыг 19,200.0 сая төгрөгөөр төлөвлөснийг 1,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 20,200.0 сая төгрөг болгох.	1,000.0
2	Газрын төлбөрийн 859.0 сая төгрөгийн татварын орлогыг 26.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж 885.4 сая төгрөгөөр төлөвлөх	26.4
3	Газрын дуудлага худалдааны орлогыг 50.0 сая төгрөгөөр төлөвлөснийг 200.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 250.0 сая төгрөгөөр төлөвлөх	200.0
4	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлогыг 70.0 сая төгрөгөөр төлөвлөснийг 418.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 488.0 сая төгрөг болгох	418.0
5	Ан амьтны нөөц ашигласны орлогыг 550.0 сая төгрөгөөр төлөвлөснийг 1,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 1,550.0 сая төгрөг болгох.	1,000.0
6	Ус, рашаан ашигласны төлбөрийн орлогыг 550.0 сая төгрөгөөр төлөвлөснийг 703.3 сая төгрөг болгон 153.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэх.	153.3
7	Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогыг 80.0 сая төгрөгөөр төлөвлөснийг 100.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 180.0 сая төгрөгөөр төлөвлөх.	100.0
	Орон нутгийн орлого нэмэгдүүлэх нийт дүн	2,897.7

ТӨСВИЙН ЗАРЛАГЫГ БУУРУУЛАХ САНАЛ

(сая төгрөг)

№	Зардлын төрөл	Мөнгөн дүн
1	Засгийн газрын 2024 оны 163 дугаар тогтоолоор Төрийн байгууллагын үйл ажиллагааг цахимжуулах хүрээнд харьяа салбар байгууллагын бичиг хэрэг, шуудангийн зардлыг 50-аас доошгүй хувиар бууруулах талаар зөвлөсөн. Аймгийн ТЕЗ-ийн нийт дүнгээр Бичиг хэргийн зардлыг 308.0 сая төгрөгөөр төлөвлөсөн бөгөөд 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 167.0 сая төгрөг зарцуулахаар тооцоо гарч байгаа тул 150.0 сая төгрөгөөр бууруулах саналтай байна.	150.0
	Төсвийн зарлагыг бууруулах дүн	150.0

оОо

ТӨСВИЙН ХӨРӨНГИЙН ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ САНАЛ

(сая төгрөг)

№	Утга	Мөнгөн дүн
1	Аймгийн ОНХС-ийн 2025 оны хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөлд иргэдийн санал аваагүй 1,900.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 900.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 2 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байгаа тул иргэдийн санал авсан төсөл, арга хэмжээг тусгаж төсвийн үр ашгийг дээшлүүлэх	900.0
2	Орон нутгийн төсвөөс 2025 онд хийгдэх төрийн болон орон нутгийн өмчийн барилга байгууламжийн их засварын жагсаалтад шинээр хэрэгжүүлэхээр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын албаны конторын засварын ажлыг 205.7 сая төгрөгөөр тусгасан нь төсвийн үр ашгийг сайжруулах шаардлагатай.	205.7
3	Авто замын сангийн хөрөнгөөр 2025 онд шинээр хэрэгжүүлэхээр тусгасан жагсаалтад 333.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 4 төсөл арга хэмжээг бүрэн санхүүжүүлэхээр тусгасан боловч тооцоолол судалгаа, зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл байхгүй тул төсөвлөлтийн шаардлага хангасан үр ашигтай төсөл арга хэмжээнд төлөвлөх.	333.8
4	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын хөрөнгөөр 2025 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад туссан төсөвлөлтийн шаардлага хангаагүй, ТЭЗҮ болон урьдчилан тооцоолол хийгээгүй 165.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 3 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөснийг хуульд нийцүүлэн үр ашгийг сайжруулах.	165.0
5	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Баянхонгор аймагт үйлдвэрлэл хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх зорилтын хүрээнд хийгдэж байнгын ашиглалтад хүлээн авсан 10,628.6 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээний үр ашгийг нэмэгдүүлэх.	10,628.6
6	Баянхонгор аймгийн ИТХ-д хандивын орлогыг төлөвлөхгүй байх саналыг уламжилж байна.	-
	Нийт дүн	12,233.1